

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн шүд эрүү нүүрний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/532/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	НТАГ-ын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn Хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayrkh@audit.gov.mn Менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantuguss@audit.gov.mn “Си Эс Ай аудит” ХХК-ийн захирал: М.Сэвжидмаа Утас: 19001981. Цахим хаяг: sevlee@yahoo.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

НИЙСЛЭЛИЙН ШҮД ЭРҮҮ НҮҮРНИЙ ТӨВИЙН ДАРГА Д.ДОЛГОРМАА ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн шүд эрүү нүүрний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны үндсэн дээр Нийслэлийн Шүд эрүү нүүрний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 479,909.9 мянган төгрөгөөр давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг ба өргөн тархсан бөгөөд санхүүгийн тайлангийн толилуулга, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, үнэн зөв, эрх үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна Тухайлбал:

- Санхүүгийн тайлан болон эд хариуцагчийн тайлангийн бараа материалын үлдэгдэл 227,573.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байсан.
- Биет тооллогоор үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 28,490.0 мянган төгрөгийн дэлгэмэл рентген аппаратыг өөр байгууллагад ашиглуулж байна.
- Хагас, бүтэн жилийн тооллого, эд хариуцагчийн ажил хүлээлцүүлэх комиссыг томилохдоо нягтлан бодогчийг тооллогын комиссын даргаар, эд хариуцагчийг гишүүнээр томилсон, тооцоог бодоогүй байна.
- Цалин хөлсийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зөв тооцоолоогүй, давхардуулан илүү олгосон, хяналт хангалтгүй, нягтлан бодох бүртгэлд зөрүүтэй тусгасан.

- Кассын нярвын тайланг шалгаж, тооцоог бодож бэлэн мөнгөний үлдэгдлийг баталгаажуулаагүй, мөн нярав чөлөөтэй, өвчтэй байх хооронд ажиллагсдыг ээлжлүүлэн ажиллуулдаг боловч тооцоог тухай бүр бодоогүй байна.
- Тус төвийн дарга нь 2022-2024 оны хугацаанд санхүү бүртгэлийн албаны ахлах нягтлан бодогчийг 5 удаа, тооцооны нягтлан бодогчийг 4 удаа, бараа материал хариуцсан эд хариуцагчийг 4 удаа тус тус өөрчилж ажлын байрны тодорхойлолтод нийцээгүй хүн томилсноос шалтгаалан санхүүгийн үйл ажиллагаа доголдож, бүртгэлээр тавих хяналт алдагдсан.
- Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй.
- Жилийн турш хүчин төгөлдөр бус баримт /шаардах хуудас/-аар бараа материал зарцуулсан.
- Байгууллагын хүчин чадлаас хэтэрсэн бүтэц орон тоо, төсөв баталснаас ажил хавсран ажиллсаны нэмэгдэл олгосон байна.
- Хан-Уул дүүрэгт байрлах салбарын үйлчилгээний төлбөрийг Эм Би Си Монголия бизнес ХХК-ийн ХААН банкны поссын 5111817636 тоот дансаар 2024 оны 06 сарын 01-12 сарын 31 хүртэл 4,642.3 мянган төгрөгийн орлого орсон нь НШЭНТ-ийн данс бүртгэлд тусгагдаагүй байна.
- Эм Би Си Монголиан бизнес консалтинг ХХК-тай 2024 онд байгуулсан үр ашиггүй “Хамтран ажиллах гэрээ”-нээс болж тус байгууллагад 34,033.6 мянган төгрөгийн алдагдал үүссэн.

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2.2-т “Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед” 13-р зүйлийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно, Төсвийн тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.12-т “Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-т “Төрийн байгууллагын орон тоо, цалин хөлсний төлөвлөлт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох” гэсэн заалттай тус тус нийцэхгүй санхүүгийн тайлагналын “тасалбар болголт”, “оршин байх”, “үнэн зөв”, “эрх үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийг 2 удаа тодотгосон бөгөөд 8 сард тендер зарлаж, худалдаж авсан 50,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн эх үүсвэрийг Эрүүл мэндийн сайдаар 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр А/546 дугаар тушаалаар 12 дугаар сарын төсвийн төлөвлөгөөний хуваарьт өөрчлөлт оруулсан, энэ хүртэл төсвийн гүйцэтгэлийн тайланд оруулахгүйгээр мэдээг зөрүүтэй гаргасан.

Тус төв нь Нийслэлийн эрүүл мэндийн газраас 158,400.0 мянган төгрөгийн эмнэлгийн зориулалтын авто машин, 288.3 мянган төгрөгийн вакцин үнэ төлбөргүй авч, хандиваар 26,110.0 мянган төгрөгийн багаж тоног төхөөрөмж, тооллогоор илэрсэн 6,600.0 төгрөгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд орлого авсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 1,200.0 мянган төгрөгийн улсын төсөв батлагдсаныг 2 удаагийн тодотголоор 8.7 хувиар нэмэгдүүлэн 1,304,987.9 мянган төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 1,560,000.0 мянган төгрөг хэвээр үлдээн баталсан байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээний 1 хөтөлбөрийн хүрээнд нийт 3,995,187.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж үйл ажиллагааны зардал 3,995,648.2 мянган төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 20.1 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайланд 850,061.5 мянган төгрөгийн Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, төлбөрт үйлчилгээний орлого, болон зардлыг хасаж тайлагнасан байхад Нийслэлийн эрүүл мэндийн газар тайланг хүлээж авч баталгаажуулсан, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 40,272.2 мянган төгрөгийн санхүүжилтийг 6 сард олгож зардлыг санхүүжүүлсний дараа 8 сард буцаан татсан, 9 сард санхүүжилт гэж залруулсан байна.Ц

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 85.2 хувьтай дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	660,498,986.39	896,420,692.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	25,336,075.00	24,875,266.61
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	1,915,310.00	
31110	Төгрөг	1,915,310.00	
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	23,420,765.00	24,875,266.61
3121	Төгрөг	23,420,765.00	
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	23,420,765.00	24,875,266.61
33	АВЛАГА	61,183,243.05	366,375,768.69
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	43,691,243.05	52,801,589.69
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	17,492,000.00	313,574,179.00
35	БАРАА МАТЕРИАЛ	573,979,668.34	511,769,657.04
351	Түүхий эд материал	248,751,843.12	206,655,401.42
35110	Тусгай зориулалттай материал	3,877,300.00	5,581,300.00
35130	Эм боох материал	244,874,543.12	201,074,101.42
35300	Бэлэн бүтээгдэхүүн	282,169,449.22	227,411,592.62
354	Хангамжийн материал	43,058,376.00	77,702,663.00
35410	Бичиг хэргийн материал	1,870,780.00	6,291,760.00
35420	Аж ахуйн материал	23,442,590.00	39,160,846.00
35440	Түлш, шатах тослох материал	90,000.00	90,000.00
35470	Бусад хангамжийн материал	17,655,006.00	32,160,057.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,889,562,861.15	4,959,686,030.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,889,562,861.15	4,959,686,030.31
392	Биет хөрөнгө	4,697,562,861.15	4,767,686,030.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,626,500,760.00	4,626,500,760.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(266,275,459.45)	(369,349,830.85)
39203	Авто тээврийн хэрэгсэл		158,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(18,480,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	795,482,600.18	933,192,600.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	(483,548,100.77)	(581,169,738.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,038,201.00	87,038,201.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(61,635,139.81)	(68,445,961.97)
393	Биет бус хөрөнгө	192,000,000.00	192,000,000.00
39301	Программ хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(770,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	192,000,000.00	192,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,550,061,847.54	5,856,706,722.65
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	218,148,195.60	532,581,275.05
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	218,148,195.60	532,581,275.05
413	Өглөг	218,148,195.60	532,581,275.05
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	125,715,845.60	272,730,205.05
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	85,004,350.00	253,679,970.00
4136	Бусад өглөг	7,428,000.00	6,171,100.00

Нийслэлийн Шүд, эрүү нүүрний төвийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41361	Байгууллагад төлөх өглөг	7,428,000.00	6,171,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,331,913,651.94	5,330,125,447.60
51	Засгийн газрын хувь оролцоо	5,331,913,651.94	5330,125,447.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	409,997,744.00	409,997,744.00
51101	Өмч:- төрийн	409,997,744.00	409,997,744.00
512	Хуримтлагдсан үр дүн	4,919,913,181.71	4,918,124,977.37
51210	Өмнөх үеийн үр дүн	5,000,408,362.68	4,924,299,886.31
51220	Тайлант үеийн үр дүн	(80,495,180.97)	(6,174,908.94)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,002,726.23	2,002,726.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,550,061,847.54	5,862,706,722.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,383,065,672.44	4,467,052,867.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,822,410.12	1,212,446,337.88
120	Нийтлэг татварын бус орлого	12,822,410.12	1,186,336,337.88
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	12,577,410.12	1,182,663,737.88
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,017,375,480.48
120009	Бусад орлого	245,000.00	3,672,600.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ		158,400,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ	12,577,410.12	6,888,257.40
122	Тусламжийн орлого		26,110,000.00
122001	Хандив тусламж/дотоод/		26,110,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,370,243,262.32	3,254,606,529.46
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,277,019,100.00	1,304,987,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,277,019,100.00	1,304,987,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	897,894,562.32	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,658,400.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	873,236,162.32	
1320	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		5,818,088.46
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,195,329,600.00	1,943,800,541.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,195,329,600.00	1,943,800,541.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,463,560,853.41	4,473,227,776.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,463,560,853.41	4,473,227,776.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,459,220,771.46	4,346,866,088.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,126,736,024.39	2,803,590,013.29
210101	Үндсэн цалин	1,098,744,892.08	1,538,786,467.79
210102	Нэмэгдэл	653,616,633.14	843,322,889.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	201,603,196.21	199,529,000.00
210104	Урамшуулал	172,771,302.96	221,951,656.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	271,858,998.21	359,504,030.83
210201	Тэтгэврийн даатгал	192,774,483.13	246,145,573.21
210202	Тэтгэмжийн даатгал	20,242,684.55	28,959,122.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,310,867.74	16,636,824.57
210204	Ажилгүйдлийн даатгал	3,754,088.21	13,455,690.76
210205	Эрүүл мэндийн даатгал	37,776,874.58	54,306,819.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,138,718.09	70,153,828.07
210301	Гэрэл, цахилгаан	33,195,683.23	31,953,588.55

Нийслэлийн Шүд, эрүү нүүрний төвийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	-	-
210303	Цэвэр, бохир ус	45,943,034.86	38,200,239.52
2104	Хангамж, бараа материалын зардал	90,683,869.23	104,707,744.18
210401	Бичиг хэрэг	72,520.00	2,510,550.00
210402	Тээвэр, шатахуун	2,673,290.00	3,342,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,372,392.90	10,372,240.18
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,552,479.00	7,603,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	71,013,187.33	80,879,314.00
210408	Бараа материал акталсны зардал	-	-
2105	Нормативт зардал	533,897,698.40	565,968,795.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	529,450,198.40	559,505,395.70
210502	Хоол, хүнс	4,447,500.00	6,463,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,820,300.00	59,802,860.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	4,048,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	79,000.00
210604	Урсгал засвар	58,820,300.00	55,675,860.00
2107	Томилолт, зочны зардал	8,460,710.00	37,884,353.00
210702	Дотоод албан томилолт	8,460,710.00	37,884,353.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,564,890.50	114,960,132.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,709,473.00	103,543,602.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,000,000.00	6,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,775,617.50	5,300,000.00
210807	Газрын төлбөр	79,800.00	116,530.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	197,059,562.64	230,294,330.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,725,000.00	2,207,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	193,334,562.64	225,986,830.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,340,081.95	126,361,687.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,882,250.00	70,952,791.06
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	39,648,651.06
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,882,250.00	31,304,140.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	55,408,896.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	55,408,896.71
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	457,831.95	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	457,831.95	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(80,495,180.97)	(6,174,908.94)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(80,495,180.97)	(6,174,908.94)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,360,282,180.77	3,995,187,417.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,185,290,690.50	1,054,155,067.48
120	Нийтлэг татварын бус орлого	1,185,290,690.50	1,054,155,067.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,180,149,336.50	1,034,867,480.48
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,177,837,600.00	1,017,375,480.48
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,311,736.50	17,492,000.00
120009	Бусад орлого	5,141,354.00	19,287,587.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,174,991,490.27	2,941,032,350.46
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,277,019,100.00	1,304,987,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,277,019,100.00	1,304,987,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	897,894,562.32	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,658,400.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	873,236,162.32	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	5,818,088.46
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	5,818,088.46
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	77,827.95	1,630,226,362.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	77,827.95	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		1,630,226,362.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,206,851,744.77	3,995,648,226.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,206,851,744.77	3,995,648,226.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,196,942,625.82	3,857,806,494.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,062,628,719.18	2,678,930,812.21
210101	Үндсэн цалин	1,223,611,683.03	1,975,154,109.10
210102	Нэмэгдэл	573,383,238.09	573,230,419.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	139,599,127.32	62,876,333.00
210104	Урамшуулал	126,034,670.74	67,669,950.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,022,491.82	352,591,448.50
210201	Тэтгэврийн даатгал	156,715,391.28	245,080,747.32
210202	Тэтгэмжийн даатгал	21,076,825.13	27,253,470.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,861,460.11	17,139,325.90
210204	Ажилгүйдлийн даатгал	4,215,365.03	11,857,389.48
210205	Эрүүл мэндийн даатгал	42,153,450.27	51,260,515.13

Нийслэлийн Шүд, эрүү нүүрний төвийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,138,718.09	70,153,828.07
210301	Гэрэл, цахилгаан	33,195,683.23	31,953,588.55
210303	Цэвэр, бохир ус	45,943,034.86	38,200,239.52
2104	Хангамж, бараа материалын зардал	71,064,924.23	76,843,251.18
210401	Бичиг хэрэг	13,275,070.00	13,251,580.00
210402	Тээвэр, шатахуун	2,673,290.00	3,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,372,392.90	9,174,240.18
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,203,800.00	7,603,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	39,540,371.33	43,114,431.00
2105	Нормативт зардал	553,410,208.00	373,175,309.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	537,892,708.00	350,727,909.00
210502	Хоол, хүнс	4,447,500.00	6,463,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,070,000.00	15,984,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,643,402.00	135,765,760.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,579,000.00	80,817,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	79,000.00
210604	Урсгал засвар	69,064,402.00	54,869,760.00
2107	Томилолт, зочны зардал	8,460,710.00	37,826,993.00
210702	Дотоод албан томилолт	8,460,710.00	37,826,993.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,768,452.50	128,211,592.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,272,005.00	115,597,062.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,000,000.00	6,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,775,617.50	6,498,000.00
210807	Газрын төлбөр	79,800.00	116,530.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	641,030.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,805,000.00	4,307,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,805,000.00	2,207,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,909,118.95	137,841,731.77
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,451,287.00	82,432,835.06
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,239,637.00	11,480,044.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		39,648,651.06
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,211,650.00	31,304,140.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	457,831.95	55,408,896.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	457,831.95	55,408,896.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	153,430,436.00	(460,808.39)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	134,906,025.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	134,906,025.00	-

Нийслэлийн Шүд, эрүү нүүрний төвийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2200	Дотоод эх үүсвэрээр	134,906,025.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	134,906,025.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(134,906,025.00)	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	18,524,411.00	(460,808.39)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,811,664.00	25,336,075.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	25,336,075.00	24,875,266.61

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	409,997,744.00	2,002,726.23	5,000,408,362.68	5,412,408,832.91
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-		
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	409,997,744.00	2,002,726.23	5,000,408,362.68	5,412,408,832.91
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-		
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-		
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-		
7	Тайлант үеийн үр дүн	-	-	(80,495,180.97)	(80,495,180.97)
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	409,997,744.00	2,002,726.23	4,919,913,181.71	5,331,913,651.94
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,386,704.60	4,386,704.60
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	409,997,744.00	2,002,726.23	4,924,299,886.31	5,336,300,356.54
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-		
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-		
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-		
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-		
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(6,174,908.94)	(6,174,908.94)
17	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	409,997,744.00	2,002,726.23	4,918,124,977.37	5,330,125,447.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,304,987,900.00	1,321,157,887.00	(16,169,987.00)	101.2
УРСГАЛ ЗАРДАЛ	1,304,987,900.00	1,321,157,887.00	(16,169,987.00)	101.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,304,987,900.00	1,321,157,887.00	(16,169,987.00)	101.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,074,776,900.00	1,045,221,161.85	29,555,738.15	97.3
Үндсэн цалин	590,577,700.00	833,845,981.71	(243,268,281.71)	141.2
Нэмэгдэл	327,627,100.00	125,632,327.74	201,994,772.26	38.4
Унаа хоолны хөнгөлөлт	81,580,000.00	32,114,112.00	49,465,888.00	39.4
Урамшуулал	74,992,100.00	53,628,740.40	21,363,359.60	71.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,347,200.00	127,499,133.38	6,848,066.62	94.9
Тэтгэврийн даатгал	91,356,000.00	93,406,678.70	(2,050,678.70)	102.2
Тэтгэмжийн даатгал	10,747,700.00	8,099,043.77	2,648,656.23	75.4
ҮОМШӨ-ний даатгал	5,373,900.00	4,493,399.89	880,500.11	83.6
Ажилгүйдлийн даатгал	5,374,000.00	3,910,022.98	1,463,977.02	72.8
Эрүүл мэндийн даатгал	21,495,600.00	17,589,988.04	3,905,611.96	81.8
Нормативт зардал				
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл				
Эд хогшил, урсгал засварын зардал	50,000,000.00	41,900,000.00	8,100,000.00	83.8
Багаж, техник, хэрэгсэл	50,000,000.00	41,900,000.00	8,100,000.00	83.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,863,800.00	106,537,591.77	(60,673,791.77)	232.2
Бусад урсгал шилжүүлэг	45,863,800.00	106,537,591.77	(60,673,791.77)	86.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,863,800.00	39,648,651.06	6,215,148.94	
Төвлөрүүлэх шилжүүлэг		55,408,896.71	(55,408,896.71)	
Бусад зардал		11,480,044.00	(11,480,044.00)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,304,987,900.00	1,321,157,887.00	(16,169,987.00)	101.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,304,987,900.00	1,321,157,887.00	(16,169,987.00)	101.2
Улсын төсвөөс санхүүжих	1,304,987,900.00	1,304,987,900.00		100.0
Бусад орлого		16,169,987.00	(16,169,987.00)	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	
Төсвийн байгууллага	1	1	1	
АЖИЛЛАГСДЫН ТОО	146	86	60	0.6
Удирдах ажилтан	1	1	1	200.0
Гүйцэтгэх ажилтан	136	82	54	59.6
Үйлчлэх ажилтан	9	3	6	33.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,674,490,339.33
УРСГАЛ ЗАРДАЛ		2,674,490,339.33
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,643,186,199.33
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,633,709,650.36
Үндсэн цалин		1,141,308,127.39
Нэмэгдэл		447,598,092.07
Унаа хоолны хөнгөлөлт		30,762,221.00
Урамшуулал		14,041,209.90
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		225,092,315.12
Тэтгэврийн даатгал		151,674,068.62
Тэтгэмжийн даатгал		19,154,426.90
ҮОМШӨ-ний даатгал		12,645,926.01
Ажилгүйдлийн даатгал		7,947,366.50
Эрүүл мэндийн даатгал		33,670,527.09
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		70,153,828.07
Гэрэл, цахилгаан		31,953,588.55
Цэвэр, бохир ус		38,200,239.52
Хангамж, бараа материалын зардал		76,843,251.18
Бичиг хэрэг		13,251,580.00
Тээвэр, шатахуун		3,700,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		9,174,240.18
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		7,603,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		43,114,431.00
Нормативт зардал		373,175,309.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		350,727,909.00
Хоол, хүнс		6,463,400.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		15,984,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		93,865,760.00
Багаж, техник, хэрэгсэл		38,917,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		79,000.00
Урсгал засвар		54,869,760.00
Томилолт, зочны зардал		37,826,993.00
Дотоод албан томилолт		37,884,353.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		128,211,592.60
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		115,597,062.60
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		6,000,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		6,498,000.00

Нийслэлийн Шүд, эрүү нүүрний төвийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Газрын төлбөр		116,530.00
Бараа үйлчилгээний бусад зардал		4,307,500.00
Бараа үйлчилгээний бусад зардал		2,100,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,207,500.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		31,304,140.00
Бусад урсгал шилжүүлэг		31,304,140.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		31,304,140.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,674,029,530.94
Нэмэлт санхүүжилтийн орлого		2,674,029,530.94
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,017,375,480.48
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		17,492,000.00
Бусад орлого		3,117,600.00
Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		1,630,226,362.00
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		5,818,088.46
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		25,336,075.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		24,875,266.61

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,255,872.4 мянган төгрөгийн 5 алдааг¹ илрүүлэн аудитын явцад залруулга хийлгэлээ.

Аудитаар нийт 531,863.3 мянган төгрөгийн 18 зөрчлийг² илрүүлж, зөрчлийг арилгуулах талаар 30,228.1 мянган төгрөгийн 6 төлбөрийн акт, 356,741.2 мянган төгрөгийн 6 албан шаардлага, 36,710.0 мянган төгрөгийн 1 сахилгын шийтгэл ноогдуулах албан шаардлага, 108,184.0 мянган төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 479,909.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул Сөрөг дүгнэлт өглөө.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Эхний хагас жилийн мөнгөн гүйлгээний тайланд Төрийн сан банканд байрлах 100200020002 тоот төгрөгийн харилцах дансаар НДХ-ээс ХЧТА-ын авлага 21,599.11 төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг орхигдуулан дутуу тайлагнасан.	1	21,599.11	1	21,599.11			1	21,599.11				
Эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан нь төсвийн гүйцэтгэлийн мэдээнээс 128,434.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	128,434.3	1	128,434.3			1	128,434.3				
Нэмэлт санхүүжилтийн данснаас 197.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан	1	197.5	1	197.5			1	197.5				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийслэлийн Шүд, эрүү нүүрний төвийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

гүйлгээг мөнгөн хөрөнгийн журналд бичилт хийгээгүйгээс журналын үлдэгдэл зөрүүтэй илэрхийлсэн байна.												
Эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн дансаар орсон ЭМД-ын сангийн 850,061.5 мянган төгрөгийн орлого зарлагын гүйлгээг орхигдуулан тайлагнасан байна.	1	850,061.5	1	850,061.5				1	850,061.5			
Бараа материалын тайлангийн эхний үлдэгдлийг санхүүгийн тайлантай тулган баталгаажуулахад эхний үлдэгдэл 255,579.9 мянган төгрөгөөр санхүүгийн тайлангаас дутуу тайлагнасан байна.	1	255,579.9	1	255,579.9								
Дүн	5	1,255,872.4	5	1,255,872.4				5	1,255,872.4			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус төвийн нэр бүхий ажилтнуудад нийт 3,528.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.	1	3,527.9	1	3,527.9								
Тус байгууллагын даргын 2024 оны Б/114 дүгээр тушаалаар нэр бүхий ажилтанд үндсэн цалинг 20 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан боловч цалин, хөлснөөс суутгал хийгээгүй, үр дүнгийн урамшуулал тооцож нийт 1,677.6 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	1,677.6	1	1,677.6								
Төвийн дарга, төсвийн шууд захирагч нь харьяалах дээд байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөртөө 8,760.6 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс тооцож олгосон байна.	1	8,760.6	1	8,760.6								

Нийслэлийн Шүд, эрүү нүүрний төвийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Албан томилолтоор ажилласан албан хаагчдын цалин, хөлсийг давтан тооцоолоход 2024 оны 9 дүгээр сард баруун бүсийн 5 аймагт ажилласан 10 албан хаагчийн хоол, унааны хөнгөлөлт 1,496.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	1,496.0	1	1,496.0								
Албан хаагчдад олгосон шагнал, урамшууллыг давтан тооцоолоход 2024 оны 4 дүгээр сард олгосон 6,922.0 мянган төгрөгөөс хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна.	1	6,922.0	1	6,922.0								
Ээлжийн амралтын олговрыг давтан тооцоолоход нэр бүхий 7 албан хаагчдад амралттай байх хугацаанд 7,844.0 мянган төгрөгийн цалин, хөлсийг давхардуулан тооцож олгосон байна.	1	7,844.0	1	7,844.0								
Тус төв нь 2024 онд албан хаагч нарт ур чадварын нэмэгдэл олгохдоо холбогдох журмын дагуу шалгуур үзүүлэлтээр ажлыг дүгнээгүй 18,643.7 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байна.	1	18,643.7			1	18,643.7						
Санхүүгийн тайлангийн программыг шинэчлэх ажлын хүрээнд бараа материалын үлдэгдлийг оруулахдаа 627 нэр төрлийн 227,573.9 мянган төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийг дутуу оруулснаас няравын тайлангийн эхний үлдэгдэл, санхүүгийн тайлангаас зөрүүтэй байгаа нь хөрөнгө үрэгдэх нөхцөл бүрдсэн байна.	1	227,573.9			1	227,573.9						
Тус төв нь эд хөрөнгийн тооллого явуулах тухай Тус төвийн даргын 2024 оны 11 сарын 08-ны өдрийн А/51 тоот нь "Эд хөрөнгийн тооллого явуулах тухай" тушаалаар тооллогын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсны дотор тооллогын комиссын даргаар нягтлан бодогч Б.Дэжидмааг, тооллогын комиссын гишүүнээр нярав О.Нандинцэцэгийг томиллон ажиллуулсан. Хөрөнгийг түүвэрт хамруулан биет тооллого хийж шалгахад 28,490.0 мянган төгрөгийн дэлгэмэл зургийн рентген аппарат агуулахад байхгүйг тодруулахад Төв аймгийн Эрүүл мэндийн газарт ашиглагдаж байгаа гэсэн тайлбар өгсөн байна.	1	28,490.0			1	28,490.0						

Нийслэлийн Шүд, эрүү нүүрний төвийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Эм Би Си Монголиан бизнес консалтинг ХХК-тай 2024 онд тус компанийн байранд салбар эмнэлгийг ажиллуулж орлогын 51 хувийг тухайн компани, 49 хувийг НШЭНТ авахаар "Хамтран ажиллах гэрээ" байгуулж ажиллсан байна. Жилийн эцэст гэрээний хэрэгжилтийг шалгаж, тооцоолол хийж үзэхэд НШЭНТ нийт 34,033.6 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн байна.	1	34,033.6			1	34,033.6					
Тус төв нь Эмнэлгийн цахим хуудсанд хөгжүүлэлт хийхээр 2,100.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан байгууллага нь үйл ажиллагааны чиглэлд нь цахим хуудас хөгжүүлэх чиглэлгүй, ажлын тайлан, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан байна.	1	2,100.0					1	2,100.0			
НЭМГ-ын даргын 2022 оны 06 сарын 10-ны өдрийн Б/73 тоот тушаалаар НШЭНТ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Д.Долгормааг томилсон, НЭМГ-ын даргын Б/178 тоот тушаалаар 2024 оны 09 сарын 30-ны өдрөөс эрхлэн НШЭНТ-ийн даргаар томилсон байна. Ажиллаж байх хугацаандаа санхүү бүртгэлийн албаны ахлах нягтлан бодогчийг 5 удаа, тооцооны нягтлан бодогчийг 4 удаа, бараа материал хариуцсан эд хариуцагчийг ажлаас 4 удаа чөлөөлж, ажлын байрны шаардлага хангахгүй, ажлын байрны тодорхойлолт зөрчиж хүмүүсийг томилж байснаас санхүү бүртгэлийн үйл ажиллагаа, бүртгэлээр тавих хяналт алдагдаж санхүүгийн тайланг буруу гаргах, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, 2024 оны 2-р улирлын тайлан 850.0 сая төгрөгийн өөрийн үйл ажиллагааны орлогоо хасаж зөрүүтэй тайлагнасан, мөнгөн касс, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл, тооллого хийж тооцоо бодох, хөрөнгөнд хяналт тавьдаггүй, эд хариуцагч нартай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулаагүй, эд хариуцагчийг ажлаас чөлөөлөхөд тооллого хийж, тооцоог бодоогүй ажил авч байгаа, өгч байгаа нярвууд өөрсдөө хүлээлцсэн, нярав ажлаас гарахдаа							1	-			

Нийслэлийн Шүд, эрүү нүүрний төвийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

бараа материалаа тоолж хүлээлгэж өгөөгүй, сургалтын албаны ажилтан хүлээж аваагүй байж ажлын байранд нэвтрэн орж бараа материал олгодог, төлбөрт үйлчилгээний төлбөр болох кассын орлого шалгаж баталгаажуулдаггүй, жилийн турш кассын тайлан зөрүүтэй журналд бичигдсэн, ЭМД-ын санд бичсэн нэхэмжлэл, тооцоо нийлж баталгаажуулсан дүн зөрүүтэй, нягтлан бодогчоор хянуулдаггүй зэрэг удирдлагын үйл ажиллагаанаас шалтгаалсан алдаа удаа дараа гарсан байна.												
Мөнгөн кассын үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй кассын тооцоог шалгаж баталгаажуулдаггүй, кассын өдөр тутмын үйл ажиллагааг буруу зохион байгуулж кассын нярав чөлөөтэй, өвчтэй байх хооронд ажиллагсдыг ээлжлүүлэн ажиллуулдаг боловч тооцоог өдөр тутам хийдэггүй, касс тоолж баталгаажуулаагүй байна.	1	-					1	-				
Бараа материалын дансны үлдэгдлийг түүвэрт хамрагдуулан биет тооллого хийхэд 6,600.0 төгрөгийн шүдний үзлэгийн багаж ком, шаазангийн аппарат 16,500.0 төгрөг, Pindex апарат 4,500.0 мянган төгрөг, Вакум мехсер 3,500.0 мянган төгрөгийн нийт 31,100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж дансанд бүртгэлгүй байна.	1	31,100.0					1	31,100.0				
Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай өндөр үнэтэй тоног төхөөрөмж бүртгэлтэй байгаа бөгөөд уг бараа материалыг тоолоогүй нярвын тайланд нэр төрлөөрөө байхгүй нийт 74,984.0 мянган төгрөг зөрүүтэй байна.	1	74,984.0					1	74,984.0				
Тус байгууллага нь 2012 он баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгааг өмнөх оны аудитаар өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан стандарт, хууль, тогтоол, дүрэм журмын өөрчлөлтийг тусган шинэчлэн батлуулан мөрдөж ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.	1	-			1	-						
Өмнөх оны аудитаар ажлаас халагдсан албан хаагчид учруулсан хохирлыг шүүхийн шийдвэрээр төлүүлж, байгууллагад учирсан хохирлыг Нийслэл дэх Төрийн аудитын газрын	1	36,710.0							1	36,710.0		

Нийслэлийн Шүд, эрүү нүүрний төвийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2024 оны 26/17810546 дугаар албан шаардлагаар нийт 28,097.3 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр тус байгууллагын дарга Д.Долгормаад өгсөн албан шаардлагыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй мөн алдаагаа давтан гаргаж 2024 оны 120 тушаалаар нийт 8,619.7 мянган төгрөгийг байгууллагын данснаас төлж нийт 36,710.0 мянган төгрөгөөр байгууллагыг хохироосон байна.												
ТБОНӨБАҮХАТ хуулийн дагуу 48,000.0 мянган төгрөгийн харуул, хамгаалалтын үйлчилгээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.	1	48,000.0			1	48,000.0						
Дүн	18	531,863.3	6	30,228.1	6	356,741.2	5	108,184.0	1	36,710.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус төвийн шилэн дансны нэгдсэн системд оруулбал зохих 171 мэдээллээс хуулийн хугацаанд оруулсан 149, хугацаа хоцроосон 20, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Тендер шалгаруулалттай холбоотой 619,857.6 мянган төгрөгийн 17 багцын ерөнхий мэдээллийг шилэн дансны нэгдсэн системд мэдээлээгүй байна.	1	619,857.6					1	619,857.6
Дүн	1	619,857.6					1	619,857.6
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тус байгууллагын даргын "Нийслэлийн шүд эрүү нүүрний төвийн орон тоо батлах тухай" 2023 оны 07 дугаар сарын 31-ны өдөр А/53 дугаар тушаалаар бүтэц орон тоог 146, Байгууллагын орон тоо, цалингийн сан тогтоох тухай 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр 1 дугаар тушаалаар, .2024 оны 04 дүгээр сарын А/23 дугаар тушаалаар Нийслэлийн шүд эрүү нүүрний төвийн 2024 оны эмч, ажилтнуудын цалингийн санг 79 орон тоотой гэрээт 3 ажилтнаар баталсан байна. Иймд тус байгууллага нь бүтэц орон тоог өөрийн хүчин чадалд таарах хэмжээгээр батлахгүй 64 орон тоог илүү батлуулсан байж ажил хавсран 4 хүн ажиллуулж байна.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Нийт дүн	2	619,857.6					2	619,857.6

